

## ТӨВ АЗИЙН ГЕОСТРАТЕГИЙН АСУУДАЛ БА МОНГОЛ УЛС

*К.Дэмбэрэл\**

### **а. Төв Азийн геостратегийн бүтцийг тодорхойлох нь**

Төв Азийн ард түмнүүд хөгжлийн түүхэндээ олон улсын харилцаанд тодорхой үүргийг гүйцэтгэсээр ирсэн. Тэдний түүхэнд уналт бууралт, мандан бадралт ч байлаа. Өөрөөр хэлбэл, тэд олон улсын үйл ажиллагаанд тодорхойлогч үүрэгтэй ч байсан, бараг мэдрэгдэхгүй шахам үе ч байсан.

Төв Ази гэдэг нь Каспийн тэнгисээс Хянганы нуруу хүртэлх өргөн удам нутаг дэвсгэр дээрх түрэг, монгол ард түмнүүдийн өлгий. Энэхүү орон зайд оршин буй улс орнуудын улс төр, эдийн засаг, соёлын харилцаа XXI зуунд ямар хандлагатай байж, түүнд Монгол Улс ямар байр суурийг эзлэхийг судлан тогтоох нь энэ чиглэлээр ажиллаж буй судлаачдын ажлын үндсэн зорилго болно. Гол асуудлаа шийдэхийн зэрэгцээ судлаач бүр дэлхийн бодлого дахь Төв Азийн ерөнхий дүр төрх, үзүүлэх нөлөөг гаргаж ирэх давхар зорилготой байх нь зүйтэй. Үндсэн зорилгоо хэрэгжүүлэхдээ Төв Азийн амьдралд нөлөөлөх бүхий л хүчин зүйлийг иж бүрнээр нь авч үзэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, дэлхийн бодлогын нэгэн салшгүй хэсэг хэмээн авч үзэх ёстой. Нэг ёсондоо, Төв Азийн улс төрийн тоглоомын мөн чанарыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлагдахууны хэмжээнд судлах явдал. Тухайн бүс нутагт багтах улсын хувьд Монгол улсыг уг системийн идэвхтэй элемент байх үүднээс энэхүү өгүүллийг бичиж байна.

Өнөөдрийн Төв Ази гэдэг нь:

1. Туркийг эс тооцвол бараг бүхэлдээ хуучин Зөвлөлтийн бүрэлдэхүүнд буюу нөлөөний хүрээнд багтаж байсан нутаг дэвсгэр,
2. Лалын шашинт ард түмнүүд зонхилсон нутаг,
3. Эдийн засгийн хөгжлийн хувьд дэлхийн хөгжлийн зах хязгаар нутаг,
4. Үндэстэн, ястан хоорондын мөргөлдөөн хялбар тархах бүс нутаг,
5. Улс төрийн хувьд тогтворгүй байдал зонхилсон бүс нутаг,

\* К.Дэмбэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

6. Байгалийн баялаг, түүний нөөцөөр арвин учир том гүрнүүдийн эдийн засгийн сонирхлын төвд буй бүс нутаг. (XXI зуунд Төв Ази нь дэлхийн эдийн засагт эрчим хүчний чухал уурхайн нэг болно. Казахстаны нефтийн судлагдсан нөөц нь 2,2 тэрбум тонн, байгалийн хийн хувьд 2,5 триллон м<sup>3</sup>, Туркменистаны байгалийн хийн нөөц нь 3 орчим тэрбум м<sup>3</sup>, Узбекистаны байгалийн хийн нөөц нь 2 орчим тэрбум м<sup>3</sup>, Каспийн тэнгисийн Казахстаны сектор болон Аралын тэнгисийн сав газрын нефтийн нөөц 13 тэрбум тонн, байгалийн хий нь 6 триллон м<sup>3</sup> бий гэсэн урьдчилсан судалгаа хийгдсэн байгаа бол Туркменистаны секторт 6,3 тэрбум тонн нефть, 15,5 тэрбум м<sup>3</sup> байгалийн хий, Узбекистаны секторт 0,3 тэрбум тонн нефть, 2 триллон м<sup>3</sup> байгалийн хий бий гэсэн судалгаа хийгдсэн)<sup>1</sup>

Төв Ази дахь хүчний харьцааг юуны түрүүн тодорхойлох нь чухал.

Дэлхийн улс төр, эдийн засгийн бүтцэд Төв Ази нь өөрийн гэсэн байр суурьтай байж байгалийн баялаг, газар зүйн байрлал, олон улсын харилцааны өвөрмөц субъект болж энэ утгаараа их гүрнүүдийн анхаарлын төвд орж ирсэн.

Дэлхийн хөгжлийн талаарх дүр зураг, нэн ялангуяа, олон улсын харилцаа болон дэлхийн бодлого судлалын шинж төрх нь тухайн судлаачийн сонгосон судалгаа шинжилгээний аргаас ихэд хамаарна. Төв Азийн геостратегийн бүтцийг “хүчний төв” хэмээх системийн онолынхны хэрэглэдэг түгээмэл ойлголтоор авч үзвэл илүү бодитой. “Хүчний төв” гэдэг нь олон улсын харилцаанд оролцогч бусад субъектуудын үйл ажиллагааг өөрийн үндэсний сонирхолдоо тохируулан захирч чадах потенциал бүхий дэлхийн бодлогын субъект юм. “Хүчний төв”-ийг хяналтын хүрээг нь харгалзан тодорхой хүрээний, бүс нутгийн мөн глобал шинжтэй хэмээн ангилна.

Төв Азид хүчний төв /хүндийн/ бий юу, бүс нутагт хэн нь хэн бэ гэдгийг тогтоохын тулд бага зэрэг онол ярих нь зайлшгүй.

Судлаачдын үзэж буйгаар гео-эдийн засгийн орон зай дахь бүс нутгийн ба глобал туйл гэдэг нь өөрийн эдийн засгийн ерөнхий чадавхиараа түүний дараа орох субъектаас дор хаяад хоёр дахин илүү байж чадах, тийм ялгарахуйц субъектыг хэлэх аж. Уг чадавхийг дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)/үндэсний нийт бүтээгдэхүүн (ҮНБ) хэмээх үзүүлэлтүүдээр дүгнэж заншсан. ДНБ-г харьцуулсан шинжилгээгээр тухайн улсын эдийн засгийн ерөнхий чадавхийг тогтоодог. Power (хүч) гэдэг нь боломж дээр тулгуурлахыг хэлнэ. Боломж

гэдэг маань ердөө эдийн засгийн чадавхи. Геостратегид “хоёр туйлт”, “олон туйлт”, “хүчний төв”, “үндэсний аюулгүй байдал”, “үндэсний сонирхол” ойлголтуудыг ашигладаг ба тэдгээр ойлголтуудын үндэс нь бүгд л хүч /Power/ юм. Төв Азийн улсууд, Азербайжан, Армен, Афганистан, Гүрж, Иран, Казахстан, Кыргызстан, Монгол, Тажикистан, Турк, Туркменистан, Узбекистанаар хязгаарлавал энэ бүс нутагт “туйл” нь Турк (186 тэрбум ам.долларын ҮНБ), түүний дараа Иран (111 тэрбум ам.доллар). Туркийг 200 хэмээн Ираныг 100 гаруй гэж барагцаалбал. Турк нь ҮНБ-ээрээ Иранаас бараг 2 дахин их байгаа нь түүнийг бүс нутгийн хэмжээний туйл байхад хүргэж байна. Төв Азид **туйл** байна харин бүс нутгийн хэмжээний **хүчний төв** энд алга. Харин дэлхийн (глобал) хэмжээний хүчний төв нь АНУ (8,3 триллон ам.доллар) болж байна.

Туйл нь идэвхтэй бөгөөд түрэмгий гадаад бодлого явуулснаар дотоод сонирхолдоо бусад акторуудыг захируулах замаар хүчний төв болон хувирдаг. Судлаачдын тооцсоноор, туйл хэмээх субъект нь хүчний төв болон хувирахад түүний гадаад улс төрийн чадавхи нь өрсөлдөгч субъектын тухайн үзүүлэлтээс даруй дөрөв дахин илүү байх ёстой. Гадаад улс төрийн чадавхи гэдэг нь (энэ ойлголтыг хүндийн төвийг тодорхойлоход ашигладаг) нэг ёсондоо тухайн улсын ГХЯ, БХЯ, мэдээлэл сурталчилгааны алба, хилийн хамгаалалтын алба, гадаадтай эдийн засгаар харилцах алба, гадаад аюулгүй байдлын алба буюу тагнуулын газар г.м. Гол асуудал бол үндэсний төсөвт гадаад улс төрийн чадавхи бүтнээрээ тусгагдаггүй. Хүчний төв нь эдийн засаг, улс төр буюу цэрэг, стратегийн хэлбэрээрээ ялгагдана. Аливаа улсын гадаад улс төрийн чадавхийн ихэнх нь үндэсний батлан хамгаалах секторт зориулагддаг. (хүснэгт N4)

Төв Азид ОХУ, БНХАУ, Европын Холбоо, Энэтхэг гэсэн бүс нутгийн чанартай томоохон сонирхлууд болон АНУ гэсэн глобал сонирхол энд солбицож байна. Гадаад улс төрийн чадавхи нь төсөвт тусгагдахдаа үйл ажиллагааны чиглэлүүдээрээ бичигддэг. Жишээ нь: 1997 онд Япон нь олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд 29,5 тэрбум ам. доллар зарсан нь үндэсний нийт бүтээгдэхүүний 0,7% болж байгаа ба Их Британи, Герман нь 19.6, 19.7 тэрбум доллар зарсан нь тэдний үндэсний нийт бүтээгдэхүүний 1.5%, 0.95% болж байгаа. Гэтэл зөрөө нь 10 тэрбум ам.доллар болж үүгээрээ Япон нь дэлхийн эдийн засгийн тавцанд ихээхэн давуу байдлыг олж авч байна гэсэн үг.

Төв Азийн бүс нутагт нөлөө бүхий хүчний төвүүдийн гадаад улс төрийн потенциал(тэрбум ам.доллар) хүснэгт №1

	АНУ	Япон	ОХУ	БНХАУ	Энэтхэг
Олон улсын үйл ажиллагаанд зориулж	21	7	2,7	-	-
Түүний тухайн улсын төсөвт ноогдох хувь(%)	1,2	0,9	8,7	-	-
Үндэсний батлан хамгаалах зардалд	277	51,2	22,4	18,4	15,0
Түүний тухайн улсын ҮНБ-д эзлэх хувь (%)	3,2	1	5,8	2,2	3,4

Гадаад бодлогын гол зорилгын минимум нь улс орныхоо эдийн засгийн масс-д хохирол учруулахгүй байх, максимум зорилго нь уг хэмжээг нэмэгдүүлэх явдал.

Европын томоохон улсуудын гадаад улс төрийн чадавхи нь / Герман, Их Британи, Франц/ чадавхи нь 40-50 тэрбум ам.доллар, харин Японы гадаад улс төрийн чадавхи нь 50 орчим тэрбум ам.доллар. Энэ нь түүнийг бүс нутгийн хүчний төв болгон хувиргах бүрэн боломжтой. БНХАУ-ын гадаад улс төрийн чадавхи нь албан ёсны статистик мэдээгээр 10-12 тэрбум ам.доллар (энэ тоо 40-50 тэрбум байж болохыг судлаачид үгүйсгэхгүй байгаа). АНУ-д энэ үзүүлэлт нь ойролцоогоор 300 тэрбум ам.доллар. Үүнээс үзвэл, АНУ нь ганцаараа глобал хэмжээний хүчний төв.

Олон улсын харилцааны түүхээс үзэхэд дэлхийн улс төрийн амьдралд “туйлшран” хөгжих явдал байсаар ирсэн. Сүүлийн 200 жилийн түүхийг тоймловол.<sup>2</sup>

<b>ХІХ зуун Европын</b>	<b>Нэг туйлт 1800-1815</b>	Олон туйлт 1816-1890	Хоёр туйлт 1891-1914
<b>ХХ зуун дэлхийн</b>	Нэг туйлт 1918-1936	Олон туйлт 1937-1941	Хоёр туйлт 1950-1989
<b>ХХІ зуун дэлхийн</b>	Нэг туйлт 1990-2025	Олон туйлт 2026-2050	Хоёр туйлт 2051+ 40-50 жил
<b>ХХІІ зуун дэлхийн</b>	Н э г т у й л т		

Тусгаар тогтнолд нь заналхийлэл бий болох онцгой тохиолдолд Азийн дотоод хэрэгт гүнзгий хутгалдсан АНУ нь тус болох юм гэсэн санааны үүднээс Америкийн оролцоог ч Азийнхан нааштай хүлээж авч байгаа. Монголчууд бид өрнөд рүү, нэн ялангуяа АНУ уруу хөгжлийн загвар, удирдлага, үзэл санаа, тусламж дэмжлэг эрсэн нүдээр харж байна. Өнөөдөр “Маршалл”-ын төлөвлөгөөний үетэй харьцуулах улс төрийн нөхцөл шалтгаан алга, тэгээд ч манайд хэрэгжүүлэх бодит

нөхцөл байхгүй. АНУ-ын үндэсний эрх ашиг ч Азид цэргээ байлгахыг шаардаж байна. Тэдний цэргүүд нь Азид байгаа явдал хоёр талын худалдаа эдийн засгийг өргөтгөх байнгын баталгаа болж байна гэж америкчууд үздэг. Төв Азид хүчний төвийн номлолоор үзвэл өөрийн гэсэн хүчний төв ч алга. Энэ утгаараа, энэхүү орон зайд бүс нутгийн болон глобал хүчний төвүүд “хүчээ үзэх” зайлшгүй нөхцөл нь болж байгаа юм. Иймээс бүс нутгийн болон глобал хэмжээний хүчний төвүүд Төв Азийн орон зайд нөлөөний хүрээний төлөө өрсөлдөх болно. Үүнд: АНУ, Хятад, Энэтхэг, Япон, ОХУ, Европын Холбоо / Герман/. *Европын Холбоо сонгодог утгаараа оршин тогтнож чадвал.* Дээрхи улсууд нь дэлхийн бодлогод нэгдүгээр эгнээнд орших бөгөөд Төв Азийн өөрсдийн хүчний төвүүд болох Иран, Турк нь дэлхийн бодлогод хоёрдугаар эгнээнд орших улсууд. Монгол Улсын хувьд газарзүйн байрлал, газар нутгийн хэмжээгээрээ бүс нутгийн хүчний төвүүдийн сонирхолд багтаж байгаа ч бүс нутгийн хүчний төвүүд болох ОХУ, Хятад улсаас үндсэндээ хэт хамааралтай. БНХАУ нь глобал хэмжээний хүчний төв болох магадлал өндөртэй. Ирэх зуунд бид том улсын бодлогын объект хэвээр байх болно. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл “ажиллахгүй” болчихлоо. Энэ нь Хятад улс супер гүрний статустай болох үед л өөрөөр хэлбэл ижил хэмжээний хоёр хүчний төв зэрэгцэн орших үед л ажиллах боломжтой. Азийн томоохон бүх улсууд цэргийн зардлаа нэмэгдүүлсээр байна. Батлан хамгаалах төсөв, түүний хэмжээгээр АНУ, ОХУ, Япон гэсэн дарааллаар байхад, түүний үр ашигтай байдлаараа бол АНУ, Япон, ОХУ гэсэн дараалалтай байгаа. Аливаа улсын power нь тухайн улс зэвсэгт хүчин, өөрийн холбоотноо, мөн ирж болох дайснаас өөрийн баазыг далдлан хамгаалах, стратегийн чанартай зам харилцаанд хяналт тавих зэрэгт боломжоо нэмэгдүүлэхэд өөрийн газарзүйн байрлалаа ямар хэмжээнд ашиглахтай шууд пропорциональ хамааралтай. Байгалийн хүчин зүйлийг ирж буй зуунд анхаарах нь юу юунаас чухал. Зарим судалгааны төвийн мэдээгээр энэ зуунд Монголын нийт газар нутгийн 30 хүртэлх хувь цөлжилтөнд хамрагдах магадлалтай. Энэ чиглэлд дэлхий нийтийн анхаарлыг хандуулах нь зүйтэй. Тэгээд ч хөгжилтэй орнуудад энэ талаар хөтөлбөр боловсруулан санхүүжүүлж байгаа. Түүнийг ч зохих хэмжээнд идэвхтэй ашиглах ёстой.

### **Б. Төв Азид гарч болох стратегийн түншлэлүүд тэдгээрийн оршин тогтнох баталгаа.**

XXI зууны эхэнд Азид бий болсон геополитикийн болон гео-эдийн засгийн нөхцлийн үндсэн шинж бол олон улсын үйл ажиллагааны

идэвхжил яах аргагүй мөн. Зүүн Азид эдийн засгийн идэвхжил илүү байгаа бол Төв Азид улс төрийн идэвхжил нь илүү. Төв Азийн геополитикийн шинэ нөхцөл байдал нь уг бүсэд сонирхол бүхий хүчний төвүүдийг гадаад бодлогын чиглэлээ бүх талаар эргэн харахыг зайлшгүй шаардаж байна. Өнөөдөр Төв Ази маань олон улсын харилцаанд ямар байр суурь эзэлж байна вэ.

Төв Азийн шинээр тусгаар тогтнолоо олсон улсуудад лалын фундаментализм сэргэх нь Орост ч, Хятадад ч ялгаагүй адилхан “толгойн өвчин”. Хятадын хувьд мусульманчуудад нь тийм нөлөө ямар байх вэ гэдэгт. Төв Азийн аль ч орны улс төрийн тогтворгүй байдал нь Хятадын Шинжаан-Уйгарт байдлыг хурцатгах магадлалтай. / 1 сая казах, 375 мянган киргиз/ Москва ч, Бээжин ч энэ бүс нутагт Турк, Иран, Саудын Арабын нөлөө орж ирэхийг тэвчихгүй. Энэтхэг ч гэсэн хуучин Зөвлөлтийн БНУ-уудад Арабын ертөнцтэй интернационалчлагдахыг сайшаахгүй. Төв Азийн эрчим хүчний нөөц нь ирээдүйн геополитикийн гол хүчин зүйл. Ирэх зуунд олон улсын харилцаанд шинэ туйлшрал үүсвэл тэр нь хүйтэн дайны үеийнх шиг үзэл сурталд тулгуурлахгүйн мэдээж. АНУ нь бусдаас илүү потенциалаа энэ зууны 25 жилд хадгалах бүрэн магадлалтай. /магадгүй 50 жил/ Бусад хүчний төвүүд маань бүс нутгийн хэмжээнд их гүрний статусыг олохын төлөө зүтгэцгээнэ. ОХУ нь эдийн засгийн потенциалаараа дэлхийд эхний 10-т орж чадахгүй байгаа ч ЗХУ-аас өвлөн авсан цөмийн потенциалаараа их гүрний статусыг хадгалах боломжтой. Ер нь ойрын ирээдүйд ОХУ, Хятад, Энэтхэг дэлхийн тавцан дээр гарч, АНУ-тай “эн зэрэгцэх” бодлогыг явуулна.

БНХАУ-ын хувьд улс төрийн тогтвортой байдлаа хадгалсаар байх тохиолдолд глобал их гүрний статусыг олох магадлал өндөртэй. Ийм тохиолдолд Энэтхэг, Орос хоёр тодорхой хугацаанд бүс нутгийн их гүрний статустайгаа үлдэх болно. Хэрвээ ОХУ нь Өрнөдтэй интеграцид орвол Европт төдийгүй Азид тогтвортой байдал идэвхжинэ. Өөр тохиолдолд бүс нутгийн аюулгүй байдалд төвөг учрах магадлалтай.

Геополитикийн хандлагын хүрээнд түүний цаашдын ландшафтын өөрчлөлтийн үр дүнд Европт, Азид, Африкт арьс өнгө, шашин, улс төрийн хүрээнд мөргөлдөөний голомт бий болно. Одоогийн их гүрнүүд олон туйлт ертөнц рүү тэмүүлж байгаа тэдний сонирхол нь АНУ-ын сонирхолтой зөрчилдөх үзэгдэл удахгүй мэдрэгдэж эхэлнэ. Дэлхийн бодлого нь 1990-ээд оноос хоёр туйлт системээс нэг туйлт системээр дамжин нэг-олон туйлт систем рүү /10-20 жил үргэлжлэх/ зүтгэнгээ

XXI зуунд урт бөгөөд жинхэнэ олон туйлт ситемд орно. З.Бжезинский хэлснээр “АНУ нь анхны бөгөөд эцсийн даян дэлхийн хэт их гүрэн байх”<sup>3</sup> болно. Өнөөдрийн АНУ-ын бодлого бол олон улсын харилцааны бүхий л амьдралд хутгалдах явдал. АНУ-ын сонирхол нь Төв Азийг “тусгаар” байлгахад оршино. Төв Азийн шинээр тусгаар тогтнолоо олсон улсуудын хувьд ОХУ, БНХАУ нь яах аргагүй өрсөлдөгчид. Хятад нь Монголын хувьд ч гэсэн эдийн засгийн хамгийн том гадаад түншийн нэг байж, нийт гадаад худалдааны 36%-ийг эзэлж байгаа.

Орос-Монголын харилцаа нь найрсаг ах дүүгийн шинж чанараас харилцан үр ашигтай харилцаанд шилжиж байгаа хэмээн өнөөгийн улс төр судлаачид үзэж байгаа. Энэ нь цаашдаа ямар үр дагаварт хүргэх, ер нь Монгол Орост юу нийлүүлж чадах, юуг ямар хэмжээгээр авч шингээж чадах вэ гэдэг энэхүү бизнесийн чадавхи дээр зайлшгүй стратегийн ач холбогдлыг давхар тавих ёстой. Орос нь Монгол дахь нөлөөгөө бүрэн алдвал Сибирь, Алс Дорнодын батлан хамгаалах зардал даруй 3 дахин өсөхөд хүрнэ<sup>4</sup>. Тиймээс хоёр орны харилцаанд зөвхөн ашиг харж хандвал юунд хүрэх нь тодорхой. Тийм учраас, Оросын Ази дахь бодлогын гурван үндсэн зорилтыг дараах маягаар тодорхойлж болно.

1. Одоо буй Уралаас цааш орших газар нутаг, өөрөөр хэлбэл, Сибирь, Алс дорнодыг алдахгүй байх.
2. Тун саяхныг хүртэл оросуудын нөлөө хүчтэй байсан Вьетнам, Монгол, Лаост байсан нөлөөгөө хагасыг нь ч гэсэн буцаан олж авах.
3. Ази, Номхон далайд хүчний харьцааг өөрчлөх

**Дүгнэлт:** Төв Азид глобал ба бүсийн нутгийн хэмжээний “тоглогчдын” сонирхол зэрэгцэн оршиж буйг анхааран Монгол улсын эрх ашигт нийцүүлэн өөрийн хөгжлийн стратегид тусгах нь чухал. Чухам энэ үүднээс л Монгол улсаас Төв Азийн орнуудтай харилцах бодлогыг боловсруулах нь зүйтэй. Нэгд: Төв Азид өөрийн гэсэн хүчний төв бий тэр нь Турк, НАТО-гийн гишүүн, АНУ-ын холбоотон улс, хоёрт: энэ бүс нутагт Хятад, Орос, Энэтхэг, АНУ, ЕХ, Япон гэсэн дэлхийн бодлогын нэгдүгээр эгнээний “тоглогчдын” сонирхол төвлөрч буй гэдгийг өөрийн гадаад бодлогод харгалзан үзэх ёстой.

Монгол улс нь бүс нутгийн бүх улсуудтай найрсаг харилцаатай, улс төр, газар нутаг, эдийн засгийн ямар нэг маргаан байхгүй. Ер нь энэ бүс нутагт итгэлцэл найрсаг байдлыг бэхжүүлэх, хүчирхийлэл, улс

төрийн тогтворгүй байдлыг аль болох гаргахгүй байх тал дээр Монгол улс байгаа.

Төв Азид Орос-Иран-Хятадын түншлэл бий болсон тохиолдолд Монгол улс хүссэн хүсээгүй татагдан орно. Бүс нутгийн болон глобал гүрнүүд Төв Азид сонирхлоо нэмэгдүүлэхийн тулд уг бүс нутаг дахь “хүндийн хүч”-ийг голлон сонирхох нь дамжиггүй. ОХУ-Энэтхэгийн түншлэл идэвхжих тохиолдолд Төв Азид чухал үүрэгтэй байх болно. БНХАУ-Пакистаны түншлэл ч мөн нөлөөтэй. Сүүлийн жилүүдэд хуучин зөвлөлтийн БНУ-уудад ОХУ-ын нөлөө сэргэх хандлагатай болсныг бодолцох нь зүйн хэрэг.

1. Монгол улс нь Төв Азийн улс орнуудын дотроос Өрнөдийн талыг баримталсан улстай илүү ойртон ажиллах, (тухайлбал, Турк, Казахстан )
2. Төв Азийн эрчим хүчний нөөцийг Монгол улсын эрчим хүчний аюулгүй байдлыг хангахад ашиглах ёстой, (одоохондоо нэг улсын нэг компаний бараг бүрэн хараат буй)
3. Төв Азийн бүс нутаг нь газарзүйн байрлалаараа Зүүн Ази, Европ, Өмнөд болон Баруун Азийн харилцаанд дахь чухал субъект тул Монгол улс нь зохих хүрээнд хамрагдах
4. Төв Ази нь дэлхийн эдийн засгийн “зах хязгаар” гэсэн ойлголтыг сааруулахад Монгол улс тодорхой чиглэлээр оролцох

### **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

1. Восток/Запад: Региональные подсистемы и региональные проблемы международных отношений. М., 2002, С.184.
2. О.Арин. 21 век: Мир без России. М., 2001, С.266.
3. Zbigniew Brzezinski. The Grand Chessboard. Basic Book. 1997, P.126.
4. К.Дэмбэрэл. Монголын гадаад орчны түүхэн харьцуулсан шинжилгээ. Иркутск., 2001. С.73.